

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний
хүрээлэнгийн 2023 оны 11 дүгээр сарын 29-ний
өдрийн 09/152 дугаар албан бичгийн хавсралт

1117145672
УКР0288 3338815

“ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ”-Д ОРУУЛАХ САНАЛ

№	Хуулийн төслийн заалт	Хуулийн төслийн заалтад өөрчлөлт оруулах санал	Тайлбар
1.	Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай	Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах тухай	
2.	3.1.4. “энхийг дэмжих ажиллагааны сургалт бэлтгэл” гэж олон улсын холбогдох байгууллага, аливаа улсын санаачилгаар зохион байгуулж байгаа тухайн энхийг дэмжих ажиллагаанд гүйцэтгэх үүргийн онцлог, тавигдах шаардлагыг хангахад чиглэсэн мэдлэг, дадлага, ур чадвар олгох, жигдрэлтийг хангах арга хэмжээний нэгдлийг.	3.1.4. “энхийг дэмжих ажиллагааны сургалт бэлтгэл” гэж олон улсын холбогдох байгууллага, аливаа улсын санаачилгаар зохион байгуулж байгаа тухайн энхийг дэмжих ажиллагаанд гүйцэтгэх үүргийн онцлог, тавигдах шаардлагыг хангахад чиглэсэн мэдлэг, дадлага, ур чадвар олгох, жигдрэлтийг хангах цогц арга хэмжээг гэж найруулах.	
3.	4.2. Энхийг дэмжих ажиллагаанд оролцохоор томилогдсон бие бүрэлдэхүүн нь сайн дурын үндсэн дээр сонгогдож, тухайн ажиллагааны өмнөх сургалт бэлтгэлд бүрэн хамрагдсан байна.	4.2. “Энхийг дэмжих ажиллагаанд оролцохоор томилогдох бие бүрэлдэхүүн нь сайн дурын үндсэн дээр сонгон шалгаруулалтад хамрагдаж , тухайн ажиллагааны өмнөх сургалт бэлтгэлд бүрэн хамрагдсан байна” гэж найруулах.	

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН



БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

E-MAIL САЙТЫН БҮТЭЦ САНАЛ ХҮСЭЛТ ХӨЛБӨӨ БАРИХ

МЭДЭЭ ▾

ЯАМНЫ ТУХАЙ ▾

ЦЭРГИЙН АЛБА ▾

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ▾

ИЛ ТОД ▾

ЦОМОГ

ШИЛЭН ДАНС

11-11 ТӨВ

MN ▾



Хууль тогтоомжийн төсөл

- Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль /Шинэчилсэн найруулга/

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлд саналаа mulknibak@mod.gov.mn, 51-263308 утсаар өгнө үү.

Яамдаас ирүүлсэн санал: 17

Иргэдээс ирүүлсэн санал: 0

- Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлал, хуулийн төсөл, хэрэгцээ, шаардлагыг урьдчилан гандан судалсан тайлан, үр нөлөөг үнэлэх судалгааны тайланд саналаа ganzorig@mod.gov.mn, 51-263308 утсаар өгнө үү.

Яамдаас ирүүлсэн санал: 16

Иргэдээс ирүүлсэн санал: 0



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ

14.11.2021 онд 09 сарын 09

Дугаар 02

Хяамбаатар 107

Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг дэмжих
ажиллагаанд цагдаагийн баг оролцуулах талаар
авах зарим арга хэмжээний тухай

"Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улсаас цагдаагийн баг оролцуулах тухай" Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарын илтгэлийг хэлэлцээд ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Их Хуралд:

Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улсаас цагдаагийн баг оролцуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

Хоёр. Монгол Улсын Засгийн газарт:

2.1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улсаас цагдаагийн баг оролцуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын хууль тогтоомжийг 2021 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд нийцүүлэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2.2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улсаас цагдаагийн баг оролцуулахад шаардагдах зардлын тооцоог гаргаж, жил бүрийн улсын төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлэх;

2.3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг дэмжих ажиллагаанд оролцох цагдаагийн багийг бэлтгэх зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж, алба хаагчдад олгох нөхөн талбэрийг зохицуулах журмыг хуульд заасны дагуу баталж мөрдүүлэх.

Гурав. Зөвсэгт хүчний Жанжин штабын даргад:

Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг дэмжих ажиллагаанд цагдаагийн баг оролцуулахтай холбоотой бэлтгэл ажил болон үүрэг гүйцэтгэхээр томилогдсон алба хаагчдын ажиллагааны өмнөх бэлтгэл, сургалт, дэдлагад дэмжлэг үзүүлэх.

Дөрөв. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн даргад:

Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүдийг мэдээллээр хангаж ажиллах.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА


МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

У.ХҮРЭЛСҮХ

Г.ЗАНДАНШАТАР

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХУУЛБАР ҮНЭН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



ХХВАЯР



**"БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ
АХМАДЫН ХОРОО"
НИЙГЭМД ҮЙЛЧИЛДЭГ
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА**

13340 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Дандарын гудамж 2, Утас: (976-11) 451778, 3458
E-mail: seniordefence@gmail.com

2023. 12. 01 № 15

танай _____-ны № _____-т

БХЯ-НЫ СТРАТЕГИЙН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА
ХУРАНДАА Ч.ГАНДИРВАА ТАНАА

“Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах
тухай” Монгол Улсын хуулийн төсөлтэй танилцлаа.
Хуулийн төсөлд тодорхойлогдсон ерөнхий агуулгыг
бүрэн дэмжиж байна. Тусгайлан нэр зааж оруулах
саналгүй болохыг илтгэе.

Хүндэтгэсэн:

ДАРГА,
ЧӨЛӨӨНД БАЙГАА
ХОШУУЧ ГЕНЕРАЛ  Д.МАГСАРЖАВ



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ
АХМАДЫН ХОРОО

13340 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 51,
Утас: 9908 0030, Факс: (976) 7015 2429,
Э-мэйл: akhmadkhoroo@gmail.com

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ
СТРАТЕГИЙН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ДАРГА ХУРАНДАА
Ч.ГАНДИРВАА ТАНАА

2023.12.04 № 39
танай 2023.11.22-ны № 03/4224-т

Хуулийн төсөлд санал өгөх тухай

Танай ирүүлсэн “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-тэй танилцаад хуулийн төслийг агуулгын хувьд дэмжиж байгаагаа илэрхийлье.

Санал: Энхийг дэмжих ажиллагаанд оролцох бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах ажлыг хэн, ямар байгууллага хариуцахыг хуулинд тодорхой зааж оруулмаар юм байна. Энэхүү төслөөр яам, агентлаг, цэргийн багийн удирдлагын алинд үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах үүрэг ногдож байгаа нь тодорхой бус юм шиг санагдлаа.

Энхийг дэмжих ажиллагаанд цагдаагийн бүлэг бие даан оролцохоор болж байна гэж ойлголоо. Ер нь улс орнууд өөрийн цэргийн байгууллагын бүтцэд байдаг цэргийн цагдаагийн нэгжийн бүрэлдэхүүнээ энхийг дэмжих ажиллагаанд оролцуулдаг. Манай улсын онцлогтой холбоотойгоор цагдаагийн бүлгээ бие даалган оролцуулахаар болж байгаа гэж ойлголоо.

ДАРГА



Д.БАДАМ



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
БАТЛАН ХАМГААЛАХЫН
ИХ СУРГУУЛЬ

**БАТЛАН ХАМГААЛАХЫН ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН**

13300 Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Улаанхуаран,
Утас: 45 39 42, Факс: (976) 7015 0173,
E-mail: info@mndu.gov.mn, http://www.mndu.gov.mn

2023.11.29 № 09/192

танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай


Таны 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 03/4224 дүгээр тоотоор ирсэн “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-д санал ирүүлэх тухай албан бичгийг хүлээн авч судлан үзлээ.

Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох зорилго, чиглэлийн хүрээнд “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл” боловсруулж байгаа нь цаг үеэ олсон, Зэвсэгт хүчин болон цагдаагийн байгууллагын энхийг дэмжих ажиллагаанд оролцох эрх зүйн чадамжийг дээшлүүлсэн ач холбогдолтой ажил болсон гэж үзэж, уг хуулийн төслийг дэмжиж байна.

“Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-д тус хүрээлэнгээс оруулах саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт..... хуудастай.

ЗАХИРАЛ
ХУРАНДАА



Д.СОДНОМЦОГ

8503000614

Alban toot 2023.11